



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.gov.mn, http://www.city.audit.mn

*2018.3.24* № *293*  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР  
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА  
Х.БОЛОРМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газраас аудит хийв.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Аудитын газар нь нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Нийслэлийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дун хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ц.ОЧИРБАТ